



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/51/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Н.Гэрэлмаа Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn Аудитор: Б.Мөнхболд Утас: 99041008 Цахим хаяг: munkhboldbo@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 108

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 310,717.2 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэн, төвлөрсөн халаалтын системд холбогдсон зэргээс нөлөөлсөн байна.

Тайлант онд төсвийн 19,610.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, орон нутгийн хөгжлийн сан, бусад эх үүсвэрээс 1,461,544.5 мянган төгрөгийн, үндсэн хөрөнгийг тус тус хүлээн авсан байна.

0702900329

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 5 хөтөлбөр, 7 зорилт, 66 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас арга хэмжээг бүрэн 100 хувь хэрэгжүүлсэн 56 биелэлт, хэрэгжих шатандаа 70 хувьтай 6 биелэлт, хэрэгжилт хангалтгүй 30 хувьтай 4 арга хэмжээ, хэрэгжээгүй 2 арга хэмжээг тус тус тайлагнаж хүргүүлснээс сумын Засаг даргаас нийт дүнгээр 94.5 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Нэг. Аудитын санал дүгнэлт

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	135,372.8	157,870.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,471,779.8	3,564,860.3
Нийт хөрөнгийн дүн	2,607,152.6	3,722,731.1
Нийт өр төлбөрийн дүн		
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,607,152.6	3,722,731.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,607,152.6	3,722,731.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	815,184.8	2,286,834.7
Үйл ажиллагааны зардлын дүн	594,561.0	1,170,599.2
Үйл ажиллагааны үр дүн	220,623.8	1,116,235.5
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	220,623.8	1,116,235.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,386,528.8	2,606,495.6
Тайлант оны үр дүн	220,623.8	1,116,235.5
Эцсийн үлдэгдэл	2,607,152.6	3,722,731.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	476,684.0	824,990.2
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	470,455.1	805,380.2
Үйл ажиллагааны ЦМГ	6,228.9	19,610.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(6,228.9)	(19,610.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		
Урсгал зардал		
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
Улсын төсвөөс санхүүжих		
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	420,537.8	719,704.4
Урсгал зардал	420,537.8	719,704.4
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	420,537.8	738,590.2
Орон нутгийн төсвөөс санхүүжих	420,537.8	738,590.2
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		

Гурав. Аудитын илрүүлэлт:

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 39.9 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн тайланд Үр дүнгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг салгаж тайлагнаагүй.
- Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө бэлтгэсэн зардлыг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнаагүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг тус тус зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 11.9 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 11.9 сая төгрөгийн 2 зөрчил² илэрч, 11.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 албан шаардлага өгсөн.

5.2 Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс байгууллага, иргэдийн дунд тэмцээн зохион байгуулах, малчдын чуулганы зардалд 11.9 сая төгрөгийн шагнал, урамшууллыг олгож үр дүнгүй зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 25.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй урсгал засварын зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар	1	20.4	-	-	1	20.4	1	20.4	-	-	-	-
	1	19.6	-	-	1	19.6	1	19.6	-	-	-	-
Дүн	2	40.0	-	-	2	40.0	2	40.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар	1	11.9	-	-	1	11.9	-	-	-	-	-	-
Дүн	1	11.9	-	-	1	11.9	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/ сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс	
							Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар	1	25.8	-	-	1	25.8	-	-
Нийт дүн	1	25.8	-	-	1	25.8	-	-



Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1		-	-
	НИЙТ	1	1	-	-	1		-	-